

**МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 06

№ 26/ТУЗ/15

Улаанбаатар хот

“Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авч,
халааслах хугацааг сунгах тухай”

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.4 дэх заалт, 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.13 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.7, 11.8 дахь заалт болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авах үйл ажиллагаа үргэлжлэх хугацааг 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл сунгасугай.
2. “Монложистикс Холдинг” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслах тухай 2025 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн №25/ТУЗ/10 тоот тогтоолд заасан бусад нөхцөлүүд болох эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт тоо, ширхэг 4,800,000 (дөрвөн сая найман зуун мянга) ширхэгээс ихгүй, эргүүлэн худалдан авах захиалгын дээд үнэ 210 (хоёр зуун арав) төгрөг/хувьцаа, нийт 1,008,000,000 (нэг тэрбум найман сая) төгрөгийн үнийн дүнгээр эргүүлэн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлүүд хэвээр үргэлжлэхийг тэмдэглэсүгэй.
3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эргүүлэн худалдан авах ажлыг зохион байгуулж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийг холбогдох мэдээллээр хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ